# Цэцэрлэг, яслийн тэргүүний ажилтны



Цэгмид Зуунмод хотын цэцэрлэгийн тэргүүний хүмүүжүүлэгчдийн нэг. Цэгмидийг цэцэрлэг яслийн тэргүүний ажилтны улсын зөвлөлгөөнд оролцох болсонд бяцхан шавь нар нь нэн их баяртай байна.



Аймгийн төвийн яслийн эрхлэгч Цэвээнжав санаачлага хариуцлага өндөртэй хүн. Иймээс түүний удирдсан ясли тус аймгийн тэргүүний яслиудын нэг болсон аж.



Аймгийн төвийн яслийн асрагч Намсрай гуай 18 жил эх нялхсын байгууллагад ажиллан хагас түм гаруй хүүхэд бойжуулж олондоо хайрлагдсан хүний нэг юм.

## Санаачлагатай эрхлэгч

Жаргалантын САА-н төвийн цэцэрлэгийн эрхлэгч Пүрвээ цэцэрлэгээ үлгэр жишээ тохижуулж байгаа гийн дээр ногоон мод тарих, цэцгийн мандал байгуулах, төрөл бүрийн ургамал идэшний ногоонуудыг хүүхдээр тариулж тэдэнд хөдөлмөрийн хүмүүжил олгож байна.

Сүүлийн 3 жилийн байдлаар бүгд 638 кг ногооны ургацыг туршлагын талбайгаас хурааж авч цэцэрлэгтээ хэрэглэсэн байна.

Эрхлэгч Пүрвээ хүүхдэд ногоо тарихад хэрэглэгдэх багажийг эцэг эхийн хүчээр хүүхдийн насны онцлогт тохируулан хийлгэж түүнийгээ хүүхдэд таниулж нэрийг нь тогтоолгож яаж ажиллуулдагийг нь зааж сургаснаас гадна хөдөлмөр хамгааллын талаар нь анхаарч хүүхэд бүрийг ажлын хувцас, нарны малгай бээлийтэй болгосон байна.

Мөн цэцэрлэгийн ажилчдын хүчээр хаягдал ашиглан сүүний лаазаар гоожуур хийж ажил хийсний дараа тогтмол гар нүүрийг нь угаалгаж заншуулжээ.

Эрхлэгч Пүрвээ халуун нартай өдөр хүүхдийг сэрүүцүүлэхийн тулд усан шүршүүрийг санаачлан хийж хүүхдийг усанд яаж ордог тухай ярьж зааж өгч элсэн дээр хэвтүүлдэг байна.

Түүнчлэн эцэг эхийн зөвлөлийг тогтмол ажиллуулж лекц яриа тогтмол хийж хүмүүжүүлэгч хүүхдийн хүчээр концерт, кукель, сүүдэр зэрэг жүжиг



тоглуулдгийн дээр «Залуу үе» гэдэг ханын сонинг сар дутам гаргадаг болжээ. Эцэг эхчүүдийг цэцэрлэгийн ажиллагаанд өргөн оролцуулж сүүлийн 3 жилд хүүхдийн сууцны урсгал засварыг тэдний хүчээр хийлгэж 800—1300 төгрөгийн орлого жил бүр оруулжээ.

Мөн хүүхдийн хоолны амт чанар нэр төрлийг олшруулахын тулд нутагтаа ургадаг гоньд мөөг жимсүүдийг түүж хэрэглэж байна.

Эрхлэгч Пүрвээ энэ жил цэцэрлэг яслийн тэргүүний ажилтны улсын зөвлөлгөөнийг угтаж заах аргын кабинет, тоглоомын тохилог талбайг байгуулж туршлагын талбайдаа 14 төрлийн ургамал тарьж анхны ургацаа хурааж жууцай 13 кг, хятад орос сонгино тогтмол хоолондоо хэрэглэж тэргүүн туршлага 5-ыг ажилдаа хэрэглэж тус зөвлөлгөөнд оролцохоор шалгараад байна.

**З. Дорж**

*Тус аймгийн төв хөдөөд цэцэрлэг 29 ажиллаж түүнд 1300-гаад багачууд, хүүхэд саатуулах газар 18-д 700 гаруй нялхас хүмүүжин бойжиж байна.*

## Ахмад хүмүүжүүлэгч

Аймгийн төвийн 2 дугаар цэцэрлэгийн хүмүүжүүлэгч Балжинням гуай энэ цэцэрлэгээр хүмүүжсэн олон зуун багачуудын хайртай хүний нэгээ. 1957 оноос тасралтгүй 11 жил ажилласан энэ ахмад хүмүүжүүлэгчтэй уулзаж цэцэрлэгийн хүүхдэд программт хичээлийг хэрхэн зааж байгаа тухайгаа ярьж өгнө үү? гэхэд

—Цэцэрлэгийн насны хүүхдэд хичээл заах ялангуяа зааж буй зүйлээ бүрэн дүүрэн ойлгуулна гэдэг тун нарийн ажил гэж би боддог.

Юуны өмнө тэдний нас биеийн онцлогт тохирсон, сонирхлыг нь татахуйц үзүүлэн таниулах байнга хэрэглэж өөрсдийнх нь урьд өмнө мэдсэн сурсан мэдлэг сонирхолд түшиглэн заах нь илүү ашигтай байдаг.

Иймучраас би хичээл бүрийг үзүүлэн таниулахтай заахыг хичээн ажилладаг.

Ингэж ажилласны үрээр энэ хичээлийн жилд тоололын хичээлд 80, төрөлх хэлний хичээлд 40, зохион бүтээх хичээлд 35, зурах наах, өнгөөр ялгахад 100 гаруй үзүүлэн хийж хичээлдээ ашигласан. Бас хүүхдэд юм сургах амьдрал орчинтой танилцуулахад янз бүрийн сэдэвт тоглоом зориуд бэлтгэн тоглуулж түүнээсээ системтэй ойлголтууд өгөх нь их үр дүнтэй байдаг. Жишээлбэл:

Миний санаачилж тоглуулсан 10 гаруй сэдэвт тоглоомоос Ямаан суурь, Тэмээчин зэрэг тоглоомууд нилээд ашигтай болсон гэж би боддог гэж ярив.

Хүмүүжүүлэгч Балжинням гуай хичээлийг бэлтгэл сайтай үр дүнтэй заа-



хын зэрэгцээ хүүхдийн бие бялдар оюун ухааныг хөгжүүлэх талаар ихээхэн анхаарч ажилладаг аж.

Энэ хичээлийн жилд өвөл зун цагийн аялал, экскурс 60 гаруй удаа зохиож хүүхдийг наранд шарах, усаар шүршин чийгтэй алчуураар арчих, массаж иллэг хийх зэргээр чийрэгжүүлдэг байна.

Мөн хүүхдийн бүтээлээр самбар гаргах, биеийн тамирын уралдаан тэмцээн зохиох, ангийнхаа аварга бүжигчид дуучдыг шалгаруулах, хүүхдүүдийн төрсөн өдрийн баярыг тэмдэглэх зэрэг хүмүүжлийн олон хэлбэрийн ажлыг зохиосон нь хүүхдийн хүмүүжилд сайн үр дүн өгчээ.

Мөн ангидаа В.И. Ленинний үйл амьдралыг харуулсан булан байгуулж Ленинний холбогдолтой гэрэл зургийн цуглуулга, альбом хийж, Ильичийн төрсөн өдөр зэрэг тэмдэглэлт өдрүүдийг тохиолдуулан сэдэвт ажил зохиох зэргээр ажиллаж байна.

Ингэж ахмад хүмүүжүүлэгч Балжинням гуай цэцэрлэг яслийн тэргүүний ажилтны улсын анхдугаар зөвлөлгөөнд шалгаран оролцох болов.

**Д.Баатар**

## Анхдугаар зөвлөлгөөний босгон дээр

Тус аймгийн цэцэрлэг, яслийн байгууллагууд цэцэрлэг, яслийн тэргүүний ажилтны улсын анхдугаар зөвлөлгөөний болзлыг хүлээн авч 2 жилийн төлөвлөгөө зохион эрхлэгч, хүмүүжүүлэгчдийн бүсийн зөвлөлгөөн хийлгэх, зарим цэцэрлэгийн эрхлэгч, хүмүүжүүлэгч нарын илтгэл сонсголыг авах, албан захидал даалгавар бичих зэргээр ажиллав.

Мөн аймгийн сурган хүмүүжүүлэх зүйн танхимаас эрхлэн „Цэцэрлэгийн эрхлэгч, хүмүүжүүлэгч нарт тусламж", „Сургууль цэцэрлэгийн залгамж холбоо" гэсэн бичмэл сэтгүүл гарган түүндээ цэцэрлэгийн эрхлэгч хүмүүжүүлэгчдийн тэргүүний туршлагаас нийтэлж байсны дээр өнгөрөгч 2 жил илүүгийн дотор төв орон нутгийн хэвлэлд 30 гаруй тэргүүн туршлага нийтлүүлжээ.

Түүнчлэн ерөнхий боловсролын сургуулийн багш нар цэцэрлэгийн хүмүүжүүлэгч нарын хамтарсан сурган хүмүүжүүлэх уншлагыг үе үе зохиолоо.

Цэцэрлэгийн хүмүүжүүлэгчдийн дунд сэдэвт, хөлөгт, хөдөлгөөнт тоглоом хийх, цэцэрлэгүүдийн хооронд тоглоомын талбай байгуулах уралдаан зарлан ажилласны дүнд 20 гаруй цэцэрлэг тоглоомын талбайгаа шинэчлэн тохижуулав.

Хичээлийн жил бүрийн эхэнд цэцэрлэгийн хүмүүжүүлэгчид, тогооч, аж ахуй нарын мэргэжил мэдлэгийг дээшлүүлэх 3—7 хоногийн семинар хийдэг болов.

Цэцэрлэг, яслийн тэргүүний ажилтны улсын анхдугаар зөвлөлгөөнийг ажлын амжилтаар угтаж байгаа цэцэрлэгийн эрхлэгч, хүмүүжүүлэгчид олон байгаагийн дотор Өнжүүл сумын «Ялалт» нэгдлийн цэцэрлэгийн эрхлэгч-хүмүүжүүлэгч Агвааны Аюуш, Жаргалант сум-сангийн аж ахуйн төвийн цэцэрлэгийн эрхлэгч Баянтөрийн Пүрвээ, Мөн Баянчандмань сумын цэцэрлэгийн эрхлэгч Лувсангийн Батжаргал, аймгийн төвийн цэцэрлэгийн хүмүүжүүлэгч Т. Балжинням, Ц. Долгор, Ч. Цэгмид, аймгийн төвийн яслийн эрхлэгч Цэвээнжав, асрагч Намсрай нарын зэрэг 14 хүн ажлаараа шалгарч улсын зөвлөлгөөнд оролцож байна. Жаргалант сумын төвийн цэцэрлэг (эрхлэгч нь Пүрвээ) сүүлийн 3 жил даралан туршлагын талбайдаа идэшний 6—9 төрлийн ногоо тарьж хүүхдүүдээр арчлуулан тэдэнд хөдөлмөрийн хүмүүжил олгож байна.

Аймгийн АДХГ Захиргааны Ардын боловсролын хэлтэс, улсын хүүхэлдэйн театртай хамтран тоглоом санаачлан хийх тойрон аялал зохиосон нь сургуулийн өмнөх насны хүүхдийг тоглоомоор хүмүүжүүлэхэд чухал хандив болсон юм. Энэ тойрон аяллын үр дүнд олон мянган төгрөгийн тоглоомтой болсноос гадна аймгийн цэцэрлэгүүдийн 70 хувь орчим нь хуруун ба сүүдэр куколь тоглодог болов. Цэцэрлэгийн хүмүүжүүлэгчид хүүхдийн ой ухааныг хөгжүүлэн, хамтын хүмүүжлийг бататган бэхжүүлэх ач холбогдол бүхий сэдэвт тоглоом олныг санаачлан тоглуулж байгаагийн дотор 1 дүгээр цэцэрлэгийн хүмүүжүүлэгч Долгорын «Авто машины гарааш», «Тосгон», Жаргалант сумын төвийн цэцэрлэгийн хүмүүжүүлэгч Мянганы «Орхон голын эрэг дээр», «Тариан талбай», «Хадлан дээр», Их хайрханы цэцэрлэгийн хүмүүжүүлэгч Доржпагмын «Манай анги», «Ардын дуучин» гэдэг сэдэвт тоглоомууд хүүхдийг хүмүүжүүлэх нөлөө сайтай болжээ.

Энэ бүхэн бол манай аймгийн сургуулийн өмнөх байгууллагуудаас хүүхдийг хүмүүжүүлэн бойжуулах ажилдаа олж байгаа амжилтыг харуулж байна.

**Ардын боловсролын хэлтсийн дарга Т.Гаваа**

# Цэцэрлэг сургуулийн холбоог бэхжүүлье

Хүүхдийн цэцэрлэг бол манай улсын ардын боловсролын системийн хамгийн анхан шатны байгууллага юм. Тийм учраас ардын боловсролын системийн байгууллагуудын ажлыг бүхэлд нь сайжруулъя гэвэл хүүхдийн цэцэрлэгийн хичээл хүмүүжлийн ажлаас эхлэх хэрэгтэй нь хэн бүхэнд тодорхой.

Манай аймгийн хэмжээгээр дунд сургуулиудын нэгдүгээр ангид элссэн сурагчдын 30-аад хувийг цэцэрлэгээр хүмүүжсэн хүүхэд эзэлж байна.

Хойшид ч хүүхдийн цэцэрлэгээс нэгдүгээр ангид элсэн суралцагчдын тоо улам олшрох болно.

Энэ нь цэцэрлэг сургуулийн залгамж холбоог улам гүнзгийрүүлэхийг шаардаж байна. Цэцэрлэг сургуулийн залгамж холбоог бэхжүүлнэ гэдэг нь юуны өмнө цэцэрлэгийн ахлах бүлгийн хүүхдүүдийг өөрөөр хэлбэл 7 настай хүүхдүүдийг бага дунд сургуулиудын нэгдүгээр ангид элсэн суралцахад нь урьдаас бэлтгэнэ гэсэн үг юм. Манай аймгийн ардын боловсролын хэлтэс, Сурган хүмүүжүүлэх ухааны кабинет энэ асуудлыг 1967—1968 оны хичээлийн жилээс эхлэн дэвшүүлэн тавьсан. Тэгэхдээ энэ асуудлыг нийт аймгийн хэмжээгээр хавтгайруулан тавиагүй юм.

Хамгийн бололцоотой гэж үзэж байгаа төвийн 2 дугаар цэцэрлэг, төвийн 10 жилийн дунд сургууль хоёрыг онцлон авч турших журмаар ажиллаж байна. Мөн онолын бага хурал хийлгэж «Цэцэрлэг сургуулийн залгамж холбоо» гэсэн илтгэлийг тавьж хэлэлцүүлсэн.

Энэ хуралд төвийн 3 дугаар цэцэрлэг, Сэргэлэнгийн бага сургууль, төвийн 10 жилийн дунд сургуулийн хүмүүжүүлэгч, багш нар, Ардын боловсролын хэлтэс, Сурган хүмүүжүүлэх ухааны кабинетын дарга, эрхлэгч, байцаагч, мэргэжилтэн нар оролцож санал бодлоо харилцан солилцов.

Үүний дараа 2 дугаар цэцэрлэгийн ахлах бүлэгт байсан бүх 7 настай хүүхдээр нэг бүлэг зохион байгуулж ажлын дадлага туршлагатай нэг багшид хариуцуулан өгсөн.

Мөн «Цэцэрлэг сургуулийн залгамж холбоо» гэсэн сэдвээр уншигчдын бага хурал нэг удаа хийж сургууль цэцэрлэгийн холбоог бэхжүүлэх тухай төвийн 10 жилийн бага ангийн багш (1967—1968 оны хичээлийн жилд, цэцэрлэгийн ахлах бүлгээс ирсэн хүүхдээр бүрэлдсэн нэг анги удирдсан) Жаргал, «Цэцэрлэг сургуулийн залгамж холбоог бэхжүүлье» гэсэн илтгэлийг цэцэрлэгийн эрхлэгч Цэрэннадмид нараар тавиулж хэлэлцүүлсэн нь үр дүнтэй болов.

Түүнчлэн Ардын боловсролын хэлтэс, Сурган хүмүүжүүлэх ухааны кабинет хамтарч цэцэрлэг сургуулийн залгамж холбоог тогтоохоод цэцэрлэг, сургуулиудад тусламж болгож «Хүүхдийн цэцэрлэг ба сургуулийн залгамж холбоо» гэсэн товхимолыг хэвлүүлж гаргав.

Энэ товхимол маань биднээс сургууль цэцэрлэгийн залгамж холбоог бэхжүүлэх анхны хөтөлбөр юм. Бидний зорилго бол программд цэцэрлэгийн насны хүүхдэд олгохоор дурьдсан мэдлэг хүмүүжлийг цаашид улам гүнзгийрүүлж эзэмшүүлэх явдал байлаа.

Сурган хүмүүжүүлэгч, сэтгэл зүйчид 6 настай хүүхдийг эрдэм номонд сургаж болно гэж баталж байна.

Ажиглалтаас үзвэл 4-5 настай хүүхэд ч гэсэн юм мэдэх юмсан гэсэн эрмэлзлэлтэй байна.

Манай оронд ялангуяа төв суурин газарт 7 настай хүүхдийг сургаж хүмүүжүүлэх бүрэн бололцоотой юм.

Юуны өмнө сургаж хүмүүжүүлэх гэж байгаа 7 настай хүүхдийг бүх талаас нь судлах хэрэгтэй юм. Энэ судалгааг бид нилээд хүүхэд дээр явуулсан. Судалгааг 2 дугаар цэцэрлэг дээр бага бүлгээс ахлах бүлэг хүртэл бүх бүлгүүд дээр явуулж байна.

Цагийн хуваарийг нарийн чанд сахидаг болгох, хүүхдийн анхаарлыг тогтворжуулах, тохиолдсон бэрхшээлд шантралгүй нэг маягийн хөдөлмөрийг нилээд удаан хугацаагаар хийж, өөрт нь тавьсан асуултыг анхааралтай сонсож бололцоогоороо хирээр хариулж, үлгэр, сонирхолтой яриа ярих, ном уншихад тэсвэртэй сонсож, түүнийг ярьж, үзсэн сонссон, ажиглаcан зүйлээ ярьж чаддаг болгох зорилтыг цэцэрлэгийн хүмүүжүүлэгч нарын өмнө дэвшүүлэн тавьсан.

Ярианд хэрэглэх үгэнд хүүхэд хариуцлагатай хандаж үгийнх нь нөөц улам нэмэгдэж, зөв хэлж ярьж чаддаг болбол тэдний сэтгэн бодох чадвар төдий чинээ нэмэгдэнэ.

Хүүхдийн үйл ажиллагааны нэг чухал хэлбэр бол тоглоом.

Энэ нь хүүхдийн хөгжилтөнд чухал нөлөө үзүүлдэг. Орчин тойрондоо болж байгаа үйл явдал аливаа зүйлийг хүүхэд ойлгох гэж их эрмэлздэг. Хүүхдүүд юмыг үргэлж асуусаар байгаад сүүлдээ сонирхол нь буурдаг. Тэгээд тэд ном уншиж чаддаг болох юмсан гэж боддог болдог.

Энэ бол сургуульд суралцах юмсан гэж бодож байгаа хэрэг шүүдээ.

Үүнийг л цэцэрлэг онцгой анхаарч энэ талаар ажил зохиох хэрэгтэй.

Ингэвэл цэцэрлэг хүүхдийг сургуульд сайн бэлт гэж өгнө. Цэцэрлэг сургуулийн залгамж холбоог бэхжүүлэхэд бид дээр дурьдсан асуудлуудыг анхааралдаа авч ажиллаж байна. 7 настай хүүхдийг сургуульд бэлтгэхэд мэдлэгийг нь зөвхөн харгалзаад зогсохгүй, тэр хүүхдийн үйл ажиллагаа, амьдралын шинэ байдал, шинэ үүрэг хариуцлага, өөрийн нөхөд, багш нартай харьцах тэр хүүхдийн хувийн харьцааг бас харгалзаж үзэх хэрэгтэй.

Сурах явдал бол биеийн ба оюуны тодорхой хүч чармайлтыг шаардах нүсэр хөдөлмөр юм. Тоо толж, бичиг үсэг заалгахын тул бодис юмс, хүмүүс ба түүний хөдөлмөр, орчны амьдрал, ургамал амьтан, амьгүй байгал, орон зай, хугацаа, олон цөөний талаар хамгийн энгийн мэдлэг олж авах хэрэгтэй болдог. Иим учраас бид 7 настай хүүхдийг сургуульд бэлтгэх ажлыг «бэлтгэл бүлэг» гэдэг нэртэйгээр байгуулж тэнд уул ажлыг явуулах нь зүйтэй гэж үзэж байна. Үүнийг бид энэ оны 9 дүгээр сараас эхлэн туршиж үзэх бодолтой. Энэ хавар ахлах бүлэг төгсөх хүүхдийг нэгдүгээр анги удирдах багш нарт хуваарилж өгсөн. Мөн цэцэрлэгийн ахлах бүлгийг төгсгөсөн багш нэгдүгээр ангид элсэн суралцсан хүүхэдтэйгээ хичээлийн жилийн эхний 7 хоногуудад багштай нь хамтарч ажиллаа.

Ер нь сургуулийн өмнөх насны хүмүүжил сургалтын бүх ситтемээр хүүхдийг шинэ харьцаа, шинэ үүргэнд бэлтгэх явдал бидний гол зорилт мөн.

Ер нь хүүхдийн цэцэрлэгийн хүмүүжүүлэгч багш нарын өмнө хүүхдийг сургаж хүмүүжүүлэх ганцхан зорилго байдаг учраас энэ талаар гарч байгаа дэвшилттэй зүйл бүхнийг бүтээлчээр ашиглах нь чухал байна. Сургуулийн сурагчдын сурлага хүмүүжлийн чанарыг сайжруулж, анги улирах, сургууль завсардах явдалтай тэмцэх зорилт тавигдаж байгаа орчин үед 7 настай хүүхдийг сургуульд сайн бэлтгэх нь чухал.

**Д. Пунцаг**

# Товч мэдээ

Саяхан Баянбараат сумын төвд тус сум-нэгдлийн тэргүүний малчдын зөвлөлгөөн болж «Малын арчилгаа маллагаа, отроор мал таргалуулах тухай» асуудал хэлэлцэв.

Зөвлөлгөөнд оролцогчид малд тарга хүч авахуулах ажил хангалтгүй зохиогдож байгааг шүүмжилж дээрх дутагдлыг засаж малд дээд зэргийн тарга хүч авахуулах ажлыг сайн зохиохын чухлыг онцлон тэмдэглэв. Мөн зөвлөлгөөнд БНМАУ-ын аврага төлчин Дагва, аймгийн аврага саальчин Шар, БНМАУ-ын Ардын Их Хурлын депутат, Бүрэн сумын хоньчин Ширчин нар оролцож өөрсдийн ажлын туршлагаа тодорхой ярив.

Мөн тус сумын, нэгдлийн зөвлөлийн хурал саяхан болж 1967 оны тайлан балансын дүн, 1968 оны зорилт, хөдөлмөр хамгааллын тухай зэрэг асуудал хэлэлцэж тодорхой заалт бүхий тогтоол шийдвэр гаргав.

**Ц. Жадамбаа**

Тунгалаг, Батсүмбэрийн САА-н 8 жилийн дунд сургуулийн 8 дугаар ангид суралцдаг.

Тэрээр өнгөрөгч онд болсон МПС-ын II чуулганд амжилттай оролцож алт, мөнгө, хүрэл медалиуд авсан манай тэргүүний тамирчин сурагчдын нэг юм.

Энэ охин аймгийн пионер сурагчдын II спартикиадад түрүүлж саяхан Дархан хотод болсон таван аймгийн бүсийн спартикиадад үе тэнгийн тамирчин найзуудтайгаа биеийн тамир спортын хүч чадлаа сорилцон өрсөлдөж 1 дүгээр байр эзэллээ.

Тунгалаг бас Улаанбаатар хотноо болох БНМАУ-ын ерөнхий боловсролын ба тусгай мэргэжлийн техникумын II спартакиадад амжилттай оролцов.

**Д. Дөрвөнжин**

Баяндэлгэр сумын үржил станцаас эрхлэн Эрдэнэ, Мөнгөнморьт, Баяндэлгэр сумдын зоо-техникчид зохиомол хээл түүлгийн техникчдийн 2 хоногийн семинар зохиов.

Семинараар үнээ нэг бүрийг бүрэн хээл авахуулахад зоо-техникчдийн хариуцлага, үнээний ороог хэрхэн түргэтгэх, үржилд ашиглах бухыг яаж бэлтгэх, түүнтэй харьцах тухай зэрэг сэдвээр хичээл заав.

**Б. Норов**

# Батлайн Даваадорж

Тус аймгийн ҮЭ-ийн зөвлөлийн бүгд хурлын гишүүн Б.Даваадорж 1937 онд Хөвсгөл аймгийн Цагаан уул суманд ард Батлайн 2 дугаар хүү болон төржээ. 1954 онд дунд сургууль, 1957 онд эдийн засгийн техникумыг тус тус төгсгөж 1957 оноос эхлэн улсад биеийн хүчин үнэлэн хөдөлмөрлөж сүүлийн жилд аймгийн ҮЭ-ийн Зөвлөлд Үйлдвэрийн хэлтсийн эрхлэгчээр ажиллаж байгаад хүнд өвчний уршгаар удтал эмчлүүлж байгаад 1968 оны 7 дугаар сарын 14-ний өдрийн 13 цагт зуурдаар нас барсан явдалд талийгаачийн гэр бүл, төрөл төрөгсдөд эмгэнэл илэрхийлье.

Талийгаач Б.Даваадоржийн ажилч хичээнгүй, даруу зан, нөхөрсөг нандин чанар бидэнд үүрд дурсагдах болно.

**Аймгийн ҮЭ-ийн Зөвлөлийн тэргүүлэгчид ҮЭ-ийн Зөвлөлийн хамт олон**

Хариуцлагатай эрхлэгчийг А.БАЯРМАГНАЙ

# ЗАРЛАЛ

Монголын Улаанзагалмайн нийгэмлэгийн 30 жилийн ойн нэрэмжит мөнгөн ба эд сугалааны хонжворын тохироог сум, САА, албан байгууллагууд нэгтгэн бүртгэж аймгийн Улаанзагалмайн нийгэмлэгийн хороонд 1968 оны 7 дугаар сарын 30-ны дотор ирүүлнэ үү!

Хонжворыг 8 дугаар сарын 1-нээс 30-ны дотор өгч дуусгана. Хугацаандаа бүртгүүлж хонжвороо авахгүй бол улсын орлогот оруулахыг урьдчилан анхааруулъя!

**Аймгийн Улаанзагалмайн нийгэмлэгийн хороо**

* * *

Зуунмод хотын харъяат Монгол овогтой Дорж нь өндөр насны тэтгэвэр авах 1051 тоот дэвтрээ мөн, Баянцогтын САА-н 2 дугаар тасгийн тракторч Авирмэд овогтой Чоймбол нь тракторын жолоочийн 1364, мотоцикль жолоодох эрхийн 10462 тоот үнэмлэх, паспортаа тус тус үрэгдүүлсэн тул хүчингүй болгов.

* * *

Баяндэлгэр сумын харъяат Чимэдцэрэн овогтой Бямба-Эрдэнэ нь 0230 ноймерын цэргийн бүртгэл гээгдүүлсэн тул хүчингүйд тооцов.

(Х—00038) «Анхдугаар таван жил» сонины үйлдвэрт хэвлэв.

Орон бүхний пролетари нар нэгдэгтүн

# Анх удаагаар ТАВАН ЖИЛ

Төв аймгийн намын хороо, А.Д.Х. Гүйцэтгэх захиргааны сонин.

21 дэх жилдээ № 54 (1743) | 1968 ОНЫ 7 ДУГААР САРЫН 20 | БЯМБА

## Арвин их хадлан авахын төлөө

МАХН—ын Төв Хороо,БНМАУ-ын Сайд нарын Зөвлөлөөс өвөл хаврын улиралд бүх малд хүрэлцэхүйц хэмжээний чанар сайтай тэжээл бэлтгэхийн чухлыг зааж тогтоол гаргаад,аймгийн нам, улс, ХАА—н байгууллага, малчид,нийт хөдөлмөрчдийн өмнө дайчин зорилт болгосон билээ.

Цаг зудын хүнд байдлаас мал аж ахуйд учирсан хохирлыг ойрын хугацаанд арилгах, дотоод нөөц боломжоог ашиглах, мал аж ахуйн материаллаг баазыг бэхжүүлэхийн эх нь 1968 оны хадлан авахаас эхлэх ёстой.

Манай аймаг энэ жил байгалийн хадлан, шүүст ба хүчит таримал тэжээл бүгд 203 мянган тонн буюу 100 гаруй мянган тонн тэжээлийн нэгж бэлтгэн авна.

Ингэснээр мал аж ахуйн нэг суурь 3—4 сарын тэжээлийн нөөцтэй болох юм.

Төлөвлөгөөт тэжээлийг цаг хугацаа алдалгүй бүрэн шим тэжээлтэй үед нь хадаж авах нь хадлангийн бэлтгэлийг сайн хангаж, тэжээл хураах зохион байгуулалтыг хир хийсэн болон олон түмнийг хэрхэн оролцуулснаас шалтгаална.

Манай ХАА—н нэгдэл, СААнуудын хадлангийн бэлтгэл урьд оныхоос давуутай байгаа сайн тал харагдаж байна.

Жаргалантын САА—н туршлагаар МААМС, САА—нуудаас бүрэн механикжсан хадлангийн бригад 15, ХАА—н нэгдлүүдээс механикжсан буюу хагас механикжсан бригад 19, морин машинт бригад 120, гар хадуурын бригад 50 гаруй ажиллана.

Баян, Баянзүрх, Заамар, Сэргэлэн, Алтанбулаг сум—нэгдлүүд, нийт СAA—нууд бэлтгэлээ сайн хийжээ.

Жаргалант, Борнуур, Гачуурт сум- САА—нууд 7 дугаар сарын 1—нээс хадландаа гарч, Жаргалантын САА 100 гаруй тонн өвс хадаж боогоод байна.

Цаг агаарын нөлөөнөөс бүх сумд хадлангаа өөрсдийн сумын нутагт бүрэн авах боломжоогүй боловч ургац сайтай сумдад очиж авах боломжоотой юм.

Нөгөө талаар манай аймгийн тариалсан бүх үр тарианаас 2 сая орчим тонн сүрэл авч болох ба ангилан хадсан тарианы сүрлийг боон авч малын тэжээлд ашиглах хэрэгтэй болно.

Хадлан, малын тэжээл бэлтгэх ажлыг зохион явуулж, цаг хугацаа алдалгүй хадаж авахын тулд хэсэг, бригад, суурийн хүчийг зохион байгуулж, аймаг сумын төвийн хүмүүсийн хүчийг бригад ба албан газраар зохион байгуулан ажиллуулах хэрэгтэй.

Малд тэжээл болдог зүйл бүхнийг голж чамлахгүйгээр бэлтгэн авах нь чухал.

Тухайлбал: Халтар хомоолыг суурь, айл бүр нөөцлөн хурааж, тал хээр, говийн сумд таана, хөмүүл, суль, бутарганыг цуглуулж авах нь зүйтэй юм.

Малын таримал тэжээлийг хурааж авах бэлтгэлийг сайн хангах хамгаалах хэрэгтэй.

Хадлан дээр ажиллаж байгаа хүмүүсийг ахуй соёлын хангамж, хэвлэл, ухуулга, киноны үйлчилгээг онцлон анхаарах, социалист уралдааныг өрнүүлж өдөр, долоо хоногоор дүгнэж байх хөдөлмөрийн норм, хөлсний хэмжээг сайтар ойлгуулах, цалин хөлсийг цагт нь олгож байх хэрэгтэй.

Монголын Хувьсгалт Залуучуудын Эвлэл, эмэгтэйчүүд, Үйлдвэрчний Эвлэлийн байгууллагаас малын тэжээл бэлтгэхэд хамгийн идэвхитэй оролцох, гишүүн нэг бүрийг тодорхой үүрэгтэй ажиллуулах, намын гишүүд, депутатууд манлайлж САА, ХАА-н нэгдэл бүр малын тэжээл бэлтгэхэд бүх хүчээ дайчилж, бүхнийг чиглүүлэх ёстой.

Нам, улсын байгууллагаас зохион байгуулалтын удирдлагаар хангах, шалгалт хяналтыг хүчтэй тодорхой явуулах САА, ХАА—н нэгдлийн ажилллагаанд туслах хэрэгтэй.

Арвин их тэжээл бэлтгэн авч мал сүргээ өсгөн үржүүлэх зорилтыг биелүүлэхэд албан хаагчид, малчид, нийт хөдөлмөрчид өөрсдийн хүчийг дайчлан томоохон хувь нэмрийг оруулна гэдэгт итгэж байна.

## Нэгдлийн зөвлөлийн хурал

Саяхан Заамар сумын «Заамар» нэгдлийн зөвлөлийн хурал болж нэгдлийн үйлдвэрлэлийн 1968 оны тэргүүн хагас жилийн ажлын тайлан ба аймгийн ХАА—н нэгдлийн Зөвлөлийн 2 дугаар хурлын шийдвэрийг биелүүлэх арга хэмжээний тухай нэгдлийн Зөвлөлийн дарга Халзангийн илтгэлийг хэлэлцэв.

Зөвлөлийн хуралд нэгдлийн зөвлөлийн гишүүн эдийн засагч Шийравдорж, ерөнхий зоо-техникч Батсүх нарын 20 шахам хүн илтгэлтэй холбогдуулан цаашид зохиох ажлын талаар тодорхой ярив. **Д.Сумъяа**

## Бага хурал, чуулганы шийдвэр амьдралд

Мөнгөнморьт сумын төв хөдөөд аймгийн намын бага хурал, чуулганы шийдвэрийг хүлээн авах хурал цуглаанууд болж байна.

Бага хурлын төлөөгч хоньчин Сэдэд, саальчин Дорж палам нар сүүний тасгуудад саальчидтай уулзалт хийж бага хурал, чуулганы шийдвэрээс ярьж танилцуулав.

Дараа нь олон хүн бага хурал, чуулганы шийдвэрийг биелүүлэхээ илэрхийлж үүрэг амлалт авав.

Мөнгөнморьт сумын «Улаанбаатар» нэгдэл улсад сүү тушаах ажлыг 7 тасаг болгон зохион байгуулж социалист уралдааныг тасаг суурь саальчдын дунд өрнүүлсний үр дүнд 240 мянган литр сүүг улсад тушаагаад байна.

Тасгуудын дотроос Намсрай эрхлэгчтэй тасаг бусдаас түрүүлж 60 мянга гаруй литр сүү өгөөд байна.

Одоо нийт тасгуудын дотор аймгийн намын 14 дүгээр бага хурал, чуулганы шийдвэрийг биелүүлэх хөдөлгөөн өрнөж сүүнийхээ төлөвлөгөөг 3 дугаар улиралд биелүүлэх зорилт тавин ажиллаж байна.

**А.Гончиг**

## Үйлдвэр аж ахуйн газрууд эхний хагас жилд

Хүнсний комбинатын хамт олон 1968 оны эхний хагас жилийн төлөвлөгөөг 103,4 хувиар биелүүлж үйлдвэрүүдийн хооронд зарласан социалист уралдаанд 1 дүгээр байр эзлэж аймгийн АДХГ Захиргаа, ҮЭ—ийн Зөвлөлийн нэгдүгээр зэргийн диплом, үнэ бүхий зүйлээр шагнагдав.

Энэ амжилтандаа тулгуурлан сүүлийн хагас жилийн үйлдвэрлэлийн даалгаврыг амжилттай биелүүлэх зориг эрмэлзлэлээр дүүрэн ажиллаж байгаагийн дээр өвлийн бэлтгэл ажлыг тусгай хуваарьтай хийж бүх бэлтгэл ажил барилга засварыг 9 дүгээр сарын 1—ний наана бүрэн дуусгах зорилттой ажиллаж байна.

Үйлдвэрийн нийт ажилчид хагас жилийнхээ төлөвлөгөө нормыг 104—138 хувиар биелүүлсний дотор намын гишүүн Осоржамаа, Банзрагч, Төмөрдулам, Дашсүрэн, эвлэлийн гишүүн Хоролсүрэн, Дарийжав, Батсүх, Цэндсүрэн, ҮЭ-ийн гишүүн Отгоо, Цэндсүрэн, Оргодол, Жамаа нарын олон ажилчид бусдаасаа давуу амжилт гаргав.

**С. Бумбуу**

Аймгийн Барилга угсралтын контором хамт олон ардын хувьсгалын 47 жилийн ойг угтаж 1968 оны 6 дугаар сарын барилга угсралтын төлөвлөгөөг 100,2 хувиар, материал үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 123,8 хувиар биелүүлсний дотор барилгачин Бор, Намсрай, Доржпагам, Жамбал, Ойдов нарын олон хүн 1968 оны эхний хагас жилийн төлөвлөгөөг 101—175 хувиар биелүүлж хөдөлмөрийн сайхан амжилт гаргажээ.

Зуунмод хотын худалдаа нийтийн хоолны газрууд их баяраа угтаж 1968 оны эхний хагас жилийн ном, бараа борлуулалтыг 100—101,1 хувиар биелүүлж 470,8 мянган төгрөгийн хоол борлуулжээ.

Мөн 11 дэлгүүр, мухлаг хагас жилийнхээ төлөвлөгөөг биелүүлсний дотор худалдагч Цэрэндэлэг, Маналжав, Дагийсүрэн, Лхамдулам, Жанчивдорж, Долгор нар сар бүрийнхээ төлөвлөгөөг давуулсан амжилтаар их баяртайгаа золгов.

Аймгийн Эрүүлийг Хамгаалах газрынхан ардын хувьсгалын 47 жилийн ойн өмнө жилийн ор хоногийн 55 хувь, амбулаторийн үзлэгийн 59,8 хувь, урьдчилан сэргийлэх тарилгын 69 хувийг гүйцэтгээд байна.

Архуст, Баянцогт, Борнуур, Жаргалант, Мөнгөнморьт, Зуунмод хотын хүүхэд саатуулах газрууд жилийн ор хоногийн 53-61 хувийг биелүүлжээ.

Аймгийн Эмийн сан жор хүлээн авалтыг 4 хувиар, эм борлуулалтыг 4,3 хувиар давуулан биелүүлжээ.

Мөн Эрчим хүчнийхэн 1968 оны эхний хагас жилийн цахилгаан борлуулалтын төлөвлөгөөг 38,7 хувиар, Замын ангийхан хагас жилийн зам засварын төлөвлөгөөг 117,8 хувиар биелүүлсэн амжилтаар ардын хувьсгалын 47 жилийн ойгоо хөдөлмөрийн өрнүүн амжилтаар угтав.

**Б.Цэрэндаш**
**Х.Аръяажав**

Мөнгөнморьт сумын 2 дугаар бригадын өдөрлөг саяхан болж өнгөрлөө.

Тус бригад хагас жилийн үйлдвэрлэлийн төлөвлөгөөг 100,6—115 хувиар биелүүлж сумын хэмжээгээр 1 дүгээр байр эзлэж социалист уралдаанд шилжин явах туг авав.

Мөн өдөрлөгөөр бригадын сайн дурын уран сайханчдын концерт, кино үзвэр, нийтийн хоолоор хөдөлмөрчдөд өргөн үйлчиллээ.

Одоо тус 2 дугаар бригадын нийт хөдөлмөрчид уралдааныхаа тугийг алдахгүйн тулд улам чармайн ажиллацгааж байна.

**Д.Мундааш**

## ХАЩАА ХУДАГ

Саяхан Угтаалцайдам сумын АДХ—ын ээлжит чуулган болж мал хашаажуулалт, өвлийн бэлтгэлийн тухай авч хэлэлцээд тодорхой заалт бүхий тогтоол гаргав. Тус сум, САА нийт малаа 2 ээлжийн хашаагаар хангах зорилт тавьж одоогийн байдлаар бог бод малын нийт 20 шахам хашаа бариад байна.

Гэвч мал аж ахуйн ферм бригадууд малын хашаа барих засварлах, тооцоо бүртгэлийг хөтлөх, малчдын хариуцлагыг дээшлүүлэх талаар муу анхаарснаас жил бүр хашааны мод материал их хэмжээгээр үрэгддэгийн дээр хашааг сэлбэж засварлаагүйгээс эвдэрч хэмхрэх, ялзарч муудах явдал ч гарч байжээ.

Иймээс малыг хашаажуулах ажилд нийт хүмүүс, албан байгууллагыг жигд оролцуулахын хамт малын хашааг барихдаа ферм, бригадын байршилт, малын төрөл нас хүйс, билчээр, усны хүрэлцээ нарны гэрэл, салхины цохилт зэргийг зөв тохируулан нутгийн хашир малчдын оролцоотой сонгон авч дулааны улиралд чанар сайтай барих хэрэгтэй байна.

**Н.Нанжид**